



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

Харилцах утас:
70112468
70112469
70112499
70112427

Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?

Хувийн ашиг сонирхол

ЗӨРЧИЛ

Нийтийн ашиг сонирхол

- Албан тушаалтан өөрөө болон хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болох эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг хэлнэ.

Хувийн ашиг сонирхол



- Албан тушаалтан хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлоос ангид тэгш шударгаар хэрэгжүүлэхийг хэлнэ.

Нийтийн ашиг сонирхол



- Хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж байгааг хэлнэ.

Ашиг сонирхлын зөрчил





Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛИЙН 7 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ХОРИГЛОЛТ

- Албан хаагчид дарамт, шахалт үзүүлэх, хөндлөнгөөс нөлөөлөх.
- Бусдад шан харамж өгөх, өгөхөөр амлах, зуучлах;
- Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;
- Төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
- Албан үүргээ гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхтай холбогдуулан бусдаас шан харамж шаардах;
- Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх;
- Албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх;
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжих;

НАНБХАСЗАСЗУСТ ХУУЛЬД ЗААСАН 12 ТӨРЛИЙН ХОРИГЛОЛТ, ХЯЗГААРЛАЛТ

- Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон **хориглолт**
- Оффшор бүсэд данс, хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт
- Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт
- Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох
- Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт
- Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт
- Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт
- Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт
- Хандив авахтай холбогдсон хязгаарлалт
- Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт
- Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт
- Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт
- Бусад орлогын хязгаарлалт



АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Кейс 1:

Танай байгууллага тусгай зөвшөөрөл, ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох ажлыг хариуцдаг. Таны хамт ажилладаг найз тань хууль тогтоомжид заасан шаардлага хангаагүй хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгож уг этгээдээс шан харамж авсныг та олж мэджээ. Таны найз орон сууцны зээлтэй, гэр бүлийн хүн нь өндөр өртөгтэй эмчилгээ хийлгэдэг төрийн албан хаагчийн цалингаас өөр орлогогүй гэдгийг та мэд


Асуулт: Энэ тохиолдолд та яах вэ? Энд ашиг сонирхлын зөрчил үүсэх үү?





Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

АВЛИГЫН ТУХАЙ МЭДЭГДЭХ ҮҮРЭГ /Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйл/



Хариулт-Кейс 1:

АЭХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт зааснаар “нийтийн” албан тушаалтан албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

Найз тань орон сууцны зээлтэй, гэр бүлийн хүн нь өндөр үнэтэй эмчилгээ хийлгэдэг нь түүнийг зөвтгөх шалтгаан биш. Тэрээр албан үүргээ гүйцэтгэхдээ албан тушаалаа урвуулан ашиглаж шаардлага хангахгүй, зөрчилтэй этгээдэд тусгай зөвшөөрөл олгож улмаар шан харамж авсан тул энэ үйлдэл нь ашиг сонирхлын зөрчлөөс хальж, авлигын гэмт хэргийн түвшинд хүрсэн байна.

2017 оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хуулиар албан тушаалын гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй болсон. Өөрөөр хэлбэл материаллаг хохирол учирсан эсэхийг үл харгалзан, албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн үйлдэл нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогдоно.



Кейс 2:

Танай байгууллага сар бүр их хэмжээний бараа материал худалдан авдаг ба өнгөрсөн хугацаанд танай байгууллагад дээрх бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж ирсэн гурван компанийн бараа нь чанар сайтай, үнэ өртгийн хувьд ч байгууллагад ашигтай байжээ. Энэ сард таны дүү танай байгууллагад дээрх бараа материалыг нийлүүлэхээр сонирхож хамгийн доод үнийн саналтайгаар оролцох зорилгоор танаас мэдээлэл хүсчээ.

Та гэрээний ажилтны хувьд бусад компанийн үнийн саналын талаар нарийн мэдээлэлтэй. Төсвийн байгууллагууд зардал хэмнэх талаар Засгийн газраас чиглэл ирүүлсэн тул та байгууллагын зардлыг хэмнэхийн тулд дүлдээ мэлээпэг өгсөн.

Асуулт: Дээрх үйлдэл нь ашиг сонирхлын зөрчилд хамаарах уу?





АЛБАНЫ МЭДЭЭЛЭЛ АШИГЛАХТАЙ ХОЛБОГДСОН ХОРИГЛОЛТ / НАНБХАСЗАСЗУСТ 10 дугаар зүйл /

Хариулт- Кейс 2:

НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 10 дугаар зүйлд заасан Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолт зөрчигдөнө.

Энэ бол ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал.

Энэ тохиолдолд тухайн байгууллага хэдийгээр зардал хэмнэсэн ч танил талдаа ашигтай байдлаар албаны мэдээллийг задруулсан нь нийтийн эрх ашигт харшилсан үйлдэл болно.

албан тушаал бууруулах сахилгын
шийтгэл хүлээлгэнэ





Кейс 3:

•..... аймгийн ... дугаар цэцэрлэгийн эрхлэгч “А” нь бүлгийн багш “О” тэтгэвэрт гарч, сул орон тоо үүсэхэд, цэцэрлэгийн багш ажилд авах тухай нийтэд зарлан мэдээлэлгүй, аймгийн Боловсрол, соёлын газарт ажлын байрны захиалга өгөлгүйгээр, “орон нутагт цэцэрлэгийн багшийн мэргэжилтэй хүн ховор байдаг” гэх шалтгаанаар, нөхрийн төрсөн дүү болох, цэцэрлэгийн багшийн сургууль төгссөн “Ч”-г багшаар томилсон байна.

- *Асуулт: “Ч”-г ажилд томилсон шийдвэр нь хууль зөрчсөн үйлдэлд хамаарах уу?*





Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт
/НАНБХАСЗАСЗУСТ 11 дүгээр зүйл/

Хариулт- Кейс 3.

“А” нь НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 11 дугаар зүйлийн 11.1 дэх хэсэгт “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн.



нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох, удаа дараа зөрчсөн этгээдийг нийтийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ

“хамаарал бүхий этгээд”- нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээд.

Мөн ажлын байрыг нийтэд зарлан мэдээлээгүй, бусад сонирхогч иргэдэд боломж олголгүйгээр “Ч”-г ажилд авсан нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах” гэж заасныг зөрчсөн үйлдэл болно.





Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт
/НАНБХАСЗАСЗУСТ 11 дүгээр зүйл/

Албан тушаалтан
албан үүргээ
гүйцэтгэхдээ:



- өөрийн болон өөртэй нь
хамаарал бүхий
этгээдийн хувийн ашиг
сонирхлыг хөндсөн;
- нэгдмэл сонирхолтой
этгээдтэй ашгийн төлөө
үйл ажиллагаа бүхий
харилцааг дуусгавар
болгосноос хойш 2
жилийн хугацаанд

ХОРИГЛОНО

захиргааны акт гаргах, удирдах,
хяналт, шалгалт хийх,
хариуцлага хүлээлгэх, гэрээ
байгуулах, эдгээрийг хэлэлцэх,
бэлтгэх, оролцох зэрэг үйл
ажиллагаа

Кейс 4:

•Нэгэн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга “Х” нь тус яамнаас төсөл сонгон шалгаруулахад түүний төрсөн дүү “Б”-ийн төсөл оролцож байгаа гэх шалтгаанаар шалгаруулалтыг дүгнэхэд оролцохоос татгалзсан ба уг төсөл шалгарсны дараа төрсөн дүү “Б”-тэй төсөл хэрэгжүүлэх гэрээг байгуулж батламжилсан.

Асуулт: “Х”-ийн авсан арга хэмжээ нь хуульд нийцэх үү?





Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙГ МЭДЭГДЭХ, ТАЙЛБАРЛАХ

- Хариулт: Кейс 4.**

Яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга “Х” нь төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцохоос татгалзсан нь хууль хэрэгжүүлсэн арга хэмжээ мөн.

Гэвч төрсөн дүү “Б”-тэй төсөл хэрэгжүүлэх гэрээг байгуулахдаа НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 8 дугаар зүйлийн

- 8.2 дахь хэсэгт “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй”;
- 8.6 дахь хэсэгт “Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

**АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЛЭХ,
ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ**

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог:	Эцэг (ах)-ийн нэр:	Нэр:
Албан тушаал:	Ажиллаж байгаа байгууллага:	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр:	Байгууллагын хаяг:	
Албан үүргийн төрөл:	Тайлбар:	

Сонирхлын зөрчилтэй эсэх Тийм Үгүй

Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан _____ би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл эзэл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

Албан тушаалын цалингийн хэмжээг 3 сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, удаа дараа зөрчсөн бол албан тушаал бууруулах, халах

Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог:	Эцэг (эх)-ийн нэр:	Нэр:
Албан тушаал:	Ажиллаж байгаа байгууллага:	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр:	Байгууллагын хаяг:	
Албан үүргийн төрөл:	Тайлбар:	

Сонирхлын зөрчилтэй эсэх Тийм Үгүй

Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан _____
би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:

Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

Дөрөв. Баталгаажуулалт.

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

..... /албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... он ... сар ... өдөр

Шийдвэрлэсэн байдал

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх Тийм Үгүй

Хэрэв "Тийм" бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй

Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй

Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

..... /албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... он ... сар ... өдөр



АВЛИГЫН ЗӨРЧИЛ

Кейс 5:

•..... аймгийн БСУГ-аас зохион байгуулсан сонгон шалгаруулалтаар сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерийн ажлын байранд хоёр иргэн шалгалт өгснөөс хэн нь ч сонгон шалгаруулалтын болзол хангаагүй.

Эдгээр хоёр иргэнээс “Ц” нь бага оноо авсан боловч олон жил ажилласан, туршлагатай багш тул сургуулийн захирал “Ө” түүнийг сургалтын менежерээр томилсон.

Асуулт: Энэ тохиолдолд ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль тогтоомж зөрчигдөх үү?





Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

ХУУЛЬ БУСААР АЛИВАА ХУВЬ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ДАВУУ БАЙДАЛ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ХОРИГЛОЛТ /АЭХ 7.1.3/

Хариулт-Кейс 5:

Сонгон шалгаруулалтын болзол хангаагүй “Ц”-г ажилд томилох шийдвэр гаргасан нь түүнд бусдаас давуу байдал олгосон үйлдэл болох ба Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах” гэж заасан хориглолтыг зөрчсөн.

Авлигын зөрчил



албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэрийг хүчингүй болгох, удаа дараа зөрчсөн этгээдийг төрийн албанаас халах сахилгын шийтгэл хүлээлгэнэ

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Кейс 6:

-ТӨХК-ийн нэгжийн даргаар томилогдохоор нэр дэвшсэн “Г”-ийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраас хянан үзээд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх тухай хариуг ТӨХК-ийн захиралд албан бичгээр хүргүүлжээ.
- ТӨХК-ийн захирал нь “Г”-гийн туршлага, ур чадварыг харгалзан, компанийн дотоод журмын дагуу ажилд томилох шийдвэр гаргасан байна.

Асуулт: Энэ тохиолдолд ТӨХК-ийн захирал ямар арга хэмжээ авах үүрэгтэй байсан бэ? Компанийн дотоод журамд заасны дагуу “Г”-г томилсон тул хууль зөрчсөн гэж үзэх үү?





Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ, ХЯНУУЛАХ ҮҮРЭГ

Хариулт- Кейс 6:

- ТӨХК-ийн захирал нь НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэгт “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдсон бол түүнийг тухайн албанд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан томилохоос татгалзах үүрэгтэй” гэж заасныг зөрчсөн.
- Илт ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдсон этгээдийг томилсон нь Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох” гэж заасныг зөрчсөн.



“Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээд нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсч болох нь тогтоогдсон, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон бол албан тушаал бууруулах, 29.2.4-т “дээрх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах хүртэл хариуцлага хүлээлгэхээр заасан.

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Кейс 7:

Нэгэн сургуулийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцээд сургууль байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан сургуулийн анхны түүхэн ном бүтээх, сургуулийн сүлд дууны клип хийх болон ойн бусад үйл ажиллагаанд шаардагдах зардлыг босгохын тулд эцэг эхчүүдэд мэдээлэл хүргэх, улмаар хандив дэмжлэг үзүүлэх санал гаргасан эцэг эхчүүдийг бүртгэж аван, хандивын үйл ажиллагааг зохион байгуулсан.

Санхүүгийн алба хандивын данс нээж, хандивлагчийн бүртгэл судалгаа гаргаж, зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан байна. Улмаар багш ажилчдаас 3 сая төгрөг, сурагчдаас /эцэг эхчүүдээс/ 20 сая төгрөгийн хандив цуглуулсан ба хандивын мөнгийг ойн үйл ажиллагаанд бүрэн зориулж, зарцуулалтыг эцэг эхийн зөвлөлд тайлагнасан.

Асуулт: Энэ тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсэх үү, хууль тогтоомжид нийцсэн үү?





Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

ХАНДИВ АВАХТАЙ ХОЛБОГДСОН ХЯЗГААРЛАЛТ /НАНБХАСЗАСЗУСТ Хуулийн 17 дугаар зүйл/

Хариулт- Кейс 7: НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 17 дугаар зүйлд

“Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд,

- ажилтны сургалт;
- үйл ажиллагааны зохион байгуулалт;
- техникийн дэмжлэг

зэрэг албан тушаалтныг **ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй** хандив, бусад санхүүгийн туслалцааг **энэ хуульд заасан хязгаарлалтад хамаарахгүй бол** авч болно гэж заасан.

Сургуулийн удирдлага нь хандив цуглуулах ажлыг зохион байгуулахын өмнө дээд шатны байгууллагаас зөвшөөрөл аваагүй нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасныг зөрчсөн. Мөн хуулийн 17.4-т “... хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно” гэж заасан. Сургуулийн удирдлагын зүгээс хандив өгсөн багш, ажилчид, сурагчидтай холбоотой шийдвэрийг 2 жилийн турш гаргахгүй байх боломжгүй тул ашиг сонирхлын зөрчил үүсгэнэ.

Албан тушаал бууруулах,
удаа дараа зөрчсөн бол
нийтийн албанаас халах
сахилгын шийтгэл
хүлээлгэнэ.



**АЛБАН ТУШААЛТАН ДАРААХ ТОХИОЛДОЛД БИЕЧЛЭН, ЭСХҮЛ БУСАД ЭТГЭЭДЭЭР ЗУУЧЛУУЛАН
ХАНДИВ ХҮСЭХ, ХАНДИВ ЦУГЛУУЛАХАД ОРОЛЦОХ, ХҮЛЭЭН АВАХЫГ ХОРИГЛОНО:**

НАНБХАСЗАСЗУСТ 17 дүгээр зүйлийн 17.5

- Хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд;
- Өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээдийн хэрэгцээнд;
- Өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны албанд нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд





АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Кейс 8:

- Нэгэн яамны ахлах мэргэжилтэн “Д” нь “Кэн” ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, ... аймагт баригдах арматурын үйлдвэрийн гадна, дотор цахилгаан хангамжийн техник, эдийн засгийн судалгаа шинжилгээ, боловсруулалт хийх, оновчтой хувилбарыг дэвшүүлэх, дүгнэлт зөвлөмж гаргах зэргээр мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажлыг хийж гүйцэтгэн, сард 2 сая төгрөгийн ажлын хөлс авахаар тохирсон ба 3 сарын турш “Кэн” ХХК-аас цалин хөлс авсан.
- Мөн тус яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталсан “Техникийн нөхцөл олгох комиссын бүрэлдэхүүний гишүүнээр “Д” томилогдсон ба комиссын хурлаар “Д” нь “Кэн” компанид техникийн нөхцөл олгохоор санал өгч, дэмжсэн байр суурь илэрхийлсэн.



Асуулт: “Д”-ийн үйлдэл хууль тогтоомжид харшилсан уу?



Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт /НАНБХАСЗАСЗУСТ 18 дугаар зүйл/



Нийтийн
албанаас
халах



Албаны эрх
мэдлээ урвуулан
ашиглаж,
шаардлага
хангахгүй
этгээдэд
техникийн
нөхцөл олгосон
бол эрүүгийн
гэмт хэрэг болно.

Хариулт- Кейс 8:

“Д” нь НАНБХАСЗАСЗУСТХуулийн 18.1 дэх хэсэгт “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн.

Албан тушаалтан дараах ажлыг давхар эрхэлж болно.

- хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил;
- багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;
- ашиг сонирхлын зөрчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг.
- Татварын албанд ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс илүүгүй, эсхүл төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, сургалт-аялал, сургалтын бусад үйл ажиллагаанаас орлого олдог бол.

Мөн “Д” нь “Кэн” ХХК-д техникийн нөхцөл олгох асуудлыг шийдвэрлэх комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, саналаа илэрхийлж оролцсон нь “Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт” буюу хуулийн 14.3-т “Албан тушаалтан дараах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө нийтийн албыг төлөөлж болохгүй”

14.3.2-т “өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хүртдэг аж ахуйн нэгж,

Кейс 9:

Татварын байцаагч “А” нь ажлын ачаалал их, цалингийн хэмжээнд сэтгэл ханамжгүй тул өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдсөн.


“А”-г ажлаасаа чөлөөлөгдсөн даруйд түүний хариуцан ажиллаж байсан уул уурхайн компани түүнд татварын байгууллагатай харилцаж ажиллах санхүүгийн ахлах менежерийн ажлыг санал болгожээ.

“А” ажил орлогогүй байсан тул энэ саналыг шууд хүлээн зөвшөөрч ажилд орсон.

Асуулт: А тухайн байгууллагад ажилд томилогдож болох уу, энд ашиг сонирхлын зөрчил үүсэх үү?



АЛБАН ТУШААЛААС ЧӨЛӨӨЛӨГДСӨНИЙ ДАРААХ ХЯЗГААРЛАЛТ
/НАНБХАСЗАСЗУСТ 21 дүгээр зүйл/



Хариулт- Кейс 9:

“А” нь НАНБХАСЗАСЗУСТ тухай хуулийн 21 дүгээр зүйлд “Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн.

Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

- урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;
- урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх;
- урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх.

Шүүгч торгох,
байгуулсан гэрээ
контрактыг
хүчингүй болгох
хариуцлага
хүлээлгэнэ



Кейс 10:

Нэгэн дүүргийн Мэргэжлийн хяналтын газрын хүнсний эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч “С” нь Хүнсний технологийн салбарын “EXPO” үзэсгэлэнгийн арга хэмжээнд улсын байцаагчийн дүрэмт хувцастай оролцож шинэ техник технологитой танилцах үедээ “AAA” компанийн шинэ хүнсний бүтээгдэхүүнийг “эрүүл аюулгүй шинэ бүтээгдэхүүн байна, иргэд маань энэ бүтээгдэхүүнийг сонгоорой” гэж хэлж сурталчилгааны бичлэгт оролцсон. “AAA” компани уг бичлэгийг телевиз, цахим мэдээллийн хэрэгслээр олон давталттайгаар нийтэд түгээсэн ба “С”-ийн оролцсон дээрх хэсэгт түүний нэр, албан тушаалыг тодорхой бичсэн тайлбартайгаар цацагдсан.



Асуулт: Энэ тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүсэх үү? “С”-ийн үйлдэл хуульд нийцэх үү?



Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

СУРТАЛЧИЛГААТАЙ ХОЛБОГДСОН ХЯЗГААРЛАЛТ
/НАНБХАСЗАСЗУСТ 13 дугаар зүйл/

Хариулт- Кейс 10:

Улсын байцаагч “С” нь албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбоогүй асуудлаар бүтээгдэхүүн сурталчилсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглоно” гэж заасныг зөрчсөн.



Албан тушаалын
цалингийн хэмжээг 3
сарын хугацаагаар 30
хувиар бууруулах
сахилгын шийтгэл
хүлээлгэнэ



Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Кейс 11:

Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга “З” нь Анагаах ухааны сургуулийн доод курсын төгсөгч болох “С”-ийг Сум дундын эмнэлгийн даргаар томилсон тушаал гаргажээ.

“З”-г сургуулийн найзыгаа удирдах албан тушаалд томилсон гэх асуудлаар сумын иргэдээс өргөдөл, гомдол ирсний дагуу аймгийн Засаг дарга түүнд хариуцлага хүлээлгэхээр сонсох ажиллагаа явуулахад “З” нь “энэ асуудлыг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж дэмжигдсэн, “С” нь төрийн үйлчилгээний удирдах албаны сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авсан, даргын зөвлөлийн хурал болон томилох тушаал гаргахын өмнө “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай маргасан тул хууль зөрчөөгүй” гэж маргасан байна.



Асуулт: “З”-гийн шийдвэр нь хуульд нийцсэн үү?



Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ МЭДЭГДЭХ, ТАЙЛБАРЛАХ
/НАНБХАСЗАСЗУСТ 8 дугаар зүйл/

Хариулт- Кейс 11:

Их сургуулийн доод курсын төгсөгч нь хууьд заасан “хамаарал бүхий этгээд” гэх ойлголтод хамаарахгүй тул “З” нь албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт /11 дүгээр зүйл/-ыг зөрчөөгүй байна.

Дээрх тохиолдолд НАНБХАСЗАСЗУСТХ-ийн 3.1.11-т заасан “ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” үүссэн гэж үзнэ.

“С”-ийг томилох асуудлыг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх, тушаал шийдвэр гаргахын өмнө дээд шатны албан тушаалтан болох аймгийн Засаг даргад “Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл”, тайлбарыг гаргаж, шийдвэр авсан тул хуульд заасан үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.




Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.



НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ

- Ашиг сонирхлын зөрчил үүссэн, эсхүл үүсч болзошгүй нөхцөл бий болсон байхад “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, **зөрчил үүссэн тухай мэдэгдэл**”, тайлбарыг гаргаагүй;
- Орон нутгийн болон Сум хөгжүүлэх сангийн төсөл зэрэг аливаа сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулаагүй, өөрийн хамаарал бүхий этгээдийн оролцсон сонгон шалгаруулалтын бүрэлдэхүүнд ажилласан;
- Удирдах албан тушаалтнууд, шийдвэр гаргахад оролцож байгаа нийтийн албан тушаалтнууд хамаарал бүхий этгээдийн эрх ашгийг хөндсөн захиргааны акт, шийдвэр гаргасан, ингэхдээ дээр дурдсан мэдэгдэл, тайлбар гаргаагүй;
- Төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулсан, дээд шатны байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр хандив, туслалцаа авсан, хандив туслалцаа өгсөн этгээдтэйгээ холбоотой шийдвэр гаргасан;
- Хууль бусаар иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгосон ;
- Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт зөрчсөн;
- Ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоотой холбоотой зөрчил түгээмэл гарч байна.





Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

**Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс.
Харилцах утас: 70112468, 70112469, 70112499, 70112427.**



МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Offshore

ОФФШОРЫН ТУХАЙ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



ОФФШОР ГЭЖ ЮУ ВЭ?*

Эртний Грекийн үед Афин хот орох, гарах бараанд хоёр хувийн татвар ногдуулж эхэлсэн учраас грекийн худалдаачид Афин хотын хилээс гадуур наймаагаа хийж эхэлсэн төдийгүй ойролцоо орших арал дээр наймаа төвлөрч, мөн тэнд татваргүй бараа дамлаж эхэлсэн нь өнөөгийн оффшорын эхлэл байжээ.

Төрийн хяналтаас ангид байх газар зүйн байршилд орших санхүүгийн байгууллага

татваргүй, эсвэл маш бага хувийн, нэр төдий татвартай газар компани байгуулж, түүгээрээ дамжуулан татвараас зугтах



НАНБХАСЗАСЗУСТХ-нд орсон нэмэлт:



2017.04.13-ны өдрийн хуулиар УИХ-аас тус хуулинд “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт” гэсэн 10¹ дүгээр зүйлийг нэмсэн.

ХАСХОМ гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд* нь **тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд** оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглоно.¹





*өөрийн нэр дээр
банкны данс нээлгэх*



*мөнгөн хөрөнгө
байршуулах*



*хөдлөх, үл хөдлөх
хөрөнгө өмчлөх*



*хувь нийлүүлэх замаар
хуулийн этгээд үүсгэн
байгуулах*



ЭРХ ЗҮЙН АКТ ХУГАЦАА



3 САР

30 хоног

УИХ-аас 2017.04.13-
нд хууль



ЗГ-ын 2017.10.04-ний
244-р тогтоолоор
2018.01.04-ний дотор



ЗГ-ын 2017.12.06-ны
326-р тогтоолоор
2018.03.06-ны дотор
дараах арга хэмжээг
авна:



2018.04.06-ны дотор
авсан арга хэмжээний
талаар АТГ-т
мэдүүлнэ.

•НАНБХАСЗАСЗУСТ
Х-нд “Оффшор
бүсэд банкны данс
эзэмших, хөдлөх,
үл хөдлөх хөрөнгө
өмчлөх, хуулийн
этгээд
байгуулахтай
холбогдсон
хориглолт” гэсэн
10¹ дүгээр зүйлийг
нэмсэн

• Оффшор бүсэд
хамаарах гадаад
улс, нутаг
дэвсгэрийн
жагсаалтыг
шинэчлэн
баталсан.

•“ОУ-ын эдийн засаг,
банк, санхүүгийн
байгууллагаас
гаргасан
жагсаалтыг
харгалзан
Монголбанк,
санхүүгийн асуудал
эрхэлсэн төрийн
захиргааны төв
байгууллагын
саналыг үндэслэн
ЗГ тогтооно”.-10^{1.3}
§

- 1.нээлгэсэн банкны
дансаа хаалгах;
- 2.банканд
байршуулсан
мөнгөн хөрөнгөө
татах;
- 3.хөдлөх, үл хөдлөх
хөрөнгийн өмчлөх
эрхийг худалдах,
шилжүүлэх, татах;
- 4.хувь нийлүүлэх
замаар хуулийн
этгээд үүсгэн
байгуулсан бол үйл
ажиллагаагаа
зогсоох, эзэмших,
ашиглах, захиран
зарцуулах эрхээ
худалдах,
шилжүүлэх,
дуусгавар болгох.

•АТГ-ын даргаас
2017 оны 129
дүгээр тушаалаар
2012 оны 91-р
тушаалд нэмэлт
оруулж, «мэдүүлэг
гаргагч албан
тушаалтан, түүний
хамаарал бүхий
этгээдээс “Оффшор
бүсэд банкны данс
эзэмших, хөдлөх,
үл хөдлөх хөрөнгө
өмчлөх, хуулийн
этгээд байгуулсан
талаарх бүртгэл”-
ийн маягт»-ыг
баталсан.




НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТАН:



4.1.§ “**нийтийн албан тушаалтан**” гэж:

- төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
- төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
- бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
- эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан.
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.;

ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭД:



3.1.5§ “**хамгаарал бүхий этгээд**” гэж тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;

НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД

НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД- хуулийн 3.1.6

Нэгдмэл сохиролтой этгээд гэдэгт ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээд



3.1.6§ "нэгдмэл сонирхолтой этгээд" гэж тухайн нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг;

Нэр дэвшихэд оффшорын талаар урьдчилан мэдүүлэх үүрэгтэй:

- ❖ Холбогдох хуулиар тогтоосон болзол, шалгуурын дагуу сонгогддог, эсхүл сонгуулийн үр дүнд томилогддог албан тушаалд нэр дэвшигч, түүний хамаарал бүхий этгээд нь нэр дэвшигчийг тухайн албан тушаалд нэр дэвшихэд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол холбогдох байгууллагад* урьдчилан мэдүүлэх үүрэгтэй³

³Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 10 дугаар зүйлийн 10¹.2 дахь хэсэг





Дараах арга хэмжээг авч, энэ талаар АТГ-т мэдүүлнэ:

❖ Сонгогддог, эсхүл сонгуулийн үр дүнд томилогддог албан тушаалд нэр дэвшигч албан тушаалд сонгогдсон, эсхүл томилогдсон тохиолдолд* тухайн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол 3 сарын дотор дараахь арга хэмжээг авч, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар 30 хоногийн дотор АТГ-т мэдүүлнэ;⁴

- 1) нээлгэсэн банкны дансаа хаалгах;
- 2) банканд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах;
- 3) хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах;
- 4) хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох.

⁴Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 10 дугаар зүйлийн 10¹.4 дэх хэсэг

ХОРИГЛОЛТ ХАМААРАХГҮЙ:

Гэхдээ албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, хөдөлмөр эрхлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хуулиар хүлээсэн **албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд** тухайн улсын банканд данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөхөд дээрх хориглолт хамаарахгүй.²

²Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 10 дугаар зүйлийн 10¹.5 дахь хэсэг

АТГ-т мэдэгдэнэ:



СУРАЛЦАХ



Эмнэлгийн тусламж,
үйлчилгээ авах

Хуулиар хүлээсэн **албаны чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд*** гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор тухайн улсын банканд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол АТГ-т бичгээр мэдэгдэнэ.⁵

⁵Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 10 дугаар зүйлийн 10¹.5 дахь хэсэг

АСЗ үүссэн, үүсч болзошгүйд тооцох үндэслэл болохгүй:⁶

- ❖ Сонгогдсон, эсхүл томилогдсон тохиолдолд тухайн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан зэргээ 3 сарын дотор **/2018.03.06-ны дотор/** нээлгэсэн банкны дансаа хаалгах, банканд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох зэрэг арга хэмжээг авч, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар 30 хоногийн дотор **2018.04.06-ний дотор** Авлигатай тэмцэх газарт мэдүүлсэн бол;

⁶Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 10 дугаар зүйлийн 10¹.6 дахь хэсэг

Offshore

Хариуцлага



7Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 10 дугаар зүйлийн 10^{1.7} дахь хэсэг, 29.2.4 дэх хэсэг

- **НИЙТИЙН албанаас халах**
- **албан тушаалтныг эгүүлэн татах үндэслэл болно. ⁷**

оффшор бүсэд
хамаарах гадаад улс,
нутаг дэвсгэрийн
жагсаалт

	Нэр (монгол хэлээр)	Нэр (англи хэлээр)
1.	Ангиль	Anguilla
2.	Андоррагийн Хант Улс	Andorra
3.	Антигуа Барбуда	Antigua & Barbuda
4.	Арабын Нэгдсэн Эмират	United Arab Emirates
5.	Аруба	Aruba
6.	Барбадос Улс	Barbados
7.	Бахамын арлууд	Bahamas
8.	Бахрейны Хаант Улс	Bahrain
9.	Белиз Улс	Belize
10.	Бермудын арал	Bermuda
11.	Ботсвана	Botswana
12.	Британийн Виржинийн арлууд	British Virgin Islands
13.	Бруней	Brunei
14.	Бүгд Найрамдах Вануату Улс	Vanuatu
15.	Бүгд Найрамдах Кипр Улс	Cyprus
16.	Бүгд Найрамдах Коста-Рика Улс	Costa Rica
17.	Бүгд Найрамдах Либериа Улс	Liberia
18.	Бүгд Найрамдах Ливан Улс	Lebanon
19.	Бүгд Найрамдах Мавритан Улс	Mauritius
20.	Бүгд Найрамдах Мальта Улс	Malta
21.	Бүгд Найрамдах Панам Улс	Panama
22.	Бүгд Найрамдах Уругвай Улс	Uruguay
23.	Гернси	Guernsey
24.	Гибралтар	Gibraltar
25.	Гренад Улс	Grenada
26.	Доминикийн Хамтын Нөхөрлөлийн Улс	Dominica
27.	Жерси	Jersey
28.	Ирланд Улс	Ireland
29.	Кайманы арлууд	Cayman Islands
30.	Куракао	Curacao
31.	Кууийн арлууд	Cook Islands
32.	Лихтенштейний Вант Улс	Liechtenstein
33.	Люксембург	Luxembourg
34.	Макао	Macao, SAR
35.	Малайз	Malaysia
36.	Маршаллын арлууд	Marshall Islands
37.	Монако	Monaco
38.	Монтсеррат Улс	Montserrat
39.	Мэний арал	Isle of Man
40.	Нидерландын Антилийн Арлууд	Netherlands Antilles
41.	Самоагийн Тусгаар улс	Independent State of Samoa
42.	Сейшелийн Арлын Бүгд Найрамдах Улс	Seychelles
43.	Сент-Винсент-Гренадин Улс	St. Vincent and Grenadines
44.	Сент-Китс-Невсийн Холбооны Улс	St. Kitts and Nevis
45.	Сент-Люси Улс	St. Lucia
46.	Сингапур	Singapore
47.	Теркс-кайкосын арлууд	Turks and Caicos Islands
48.	Хонконг	Hong Kong, SAR
49.	Швейцар	Switzerland



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА